



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймгийн Нөмрөг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/182/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улиастай сум
2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatar.kh@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК -н аудитор: Р.Мядагмаа

Утас: 99201964

Цахим хаяг: myadagmaa99201964@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улаанбаатар, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2024.02.17 № 1321
Тайлбар: _____

НӨМРӨГ СУМЫН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Л. БАДАМГАРАВ-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нөмрөг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нөмрөг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нөмрөг сумын Хүүхдийн цэцэрлэг нь хөрөнгө оруулалтаар ирсэн 29,185.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дансанд бүртгэж, 6,391.0 мянган төгрөгийн бараа материалыг хууль журамд заасны дагуу акталж, данс бүртгэлээс хасчээ.

Аудитын гол асуудал

Нөмрөг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар арга зүйчид үр дүнгийн урамшуулал олгосон, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 67 нэр төрлийн 41,043.1 мянган төгрөгийн хөрөнгийн бүтгэлийг цэгцлэх арга хэмжээ авч ажиллаагүй болон эд хариуцагч солигдоход эд хөрөнгийн тооллого хийж, тооцоо бодоогүй, шинээр нэмэгдсэн 2955 м.кв газрыг үнэлж, данс бүртгэлд тусгаагүй, бүртгэлтэй 6031 м.кв газрын гэрчилгээг шинэчлээгүй, шилэн дансанд байршуулах мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Нөмрөг сумын Хүүхдийн цэцэрлэг нь тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 60 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл 95 хувьтай үнэлэгдсэн байна. Тайлант онд 15 орон тоотой, 455,408.3 мянган төгрөгийн санхүүжилт

D/dlsk/Албан бичиг/Дүгнэлт,

авч 432,070.1 мянган төгрөгийг зарцуулж, 62,332.1 мянган төгрөгийн дансны үлдэгдэлтэй ажиллажээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР


Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

ДАНС	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	88,682,526.01	104,970,920.37
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	38,693,909.01	60,899,870.37
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	38,693,909.01	60,899,870.37
3121	Төгрөг	38,693,909.01	60,899,870.37
31211	Төрийн сангийн харилцах	38,693,909.01	60,899,870.37
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-
33	АВЛАГА	-	-
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	49,988,617.00	44,071,050.00
351	Түүхий эд материал	40,321,414.00	34,720,704.00
35110	Тусгай зориулалттай материал	40,321,414.00	34,720,704.00
354	Хангамжийн материал	9,667,203.00	9,350,346.00
35410	Бичиг хэргийн материал	517,000.00	772,800.00
35420	Аж ахуйн материал	839,000.00	2,638,000.00
35440	Түлш шатах тослох материал	-	186,100.00
35450	Барилгын засварын материал	1,291,200.00	500,000.00
35460	Хүнсний материал	3,138,003.00	1,371,446.00
35470	Бусад хангамжийн материал	3,882,000.00	3,882,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	327,837,458.23	337,360,817.36
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	327,837,458.23	337,360,817.36
392	Биет хөрөнгө	314,455,458.23	323,978,817.36
39201	Барилга, байгууламж	311,718,288.17	311,718,288.17
39202	Хуримтлагдсан элэгдэл	(35,947,253.88)	(45,240,325.32)
39205	Машин, тоног төхөөрөмж	68,744,735.00	85,930,335.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(34,313,636.49)	(42,197,759.83)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,684,775.90	30,684,775.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,516,650.47)	(17,001,696.56)
39214	Бусад үндсэн хөрөнгө	300,000.00	300,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(300,000.00)	(300,000.00)
39217	Номын фонд	85,200.00	85,200.00
393	Биет бус хөрөнгө	13,382,000.00	13,382,000.00
39301	Програм хангамж	1,650,000.00	1,650,000.00
39302	Хасагдуулга	(330,000.00)	(330,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	12,062,000.00	12,062,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	416,519,984.24	442,331,737.73
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
413	Өглөг	-	-
4136	Бусад өглөг	-	-
41361	Байгууллагад төлөх өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	416,519,984.24	442,331,737.73
51	Засгийн газрын хувь оролцоо	416,519,984.24	442,331,737.73
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	39,358,810.00	39,358,810.00
51101	Өмч: -Төрийн өмч	39,358,810.00	39,358,810.00
512	Хуримтлагдсан үр дүн	226,070,141.02	251,881,894.51
51210	Өмнөх үеийн үр дүн	194,549,743.29	194,549,743.29
51220	Тайлант үеийн үр дүн	31,520,397.73	57,332,151.22
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	151,091,033.22	151,091,033.22
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	416,519,984.24	442,331,737.73

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

ДАНС	ITEM_NAME	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	338,246,184.00	484,893,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,779,984.00	29,185,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	35,779,984.00	29,185,600.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	35,779,984.00	29,185,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	35,779,984.00	29,185,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	302,466,200.00	455,408,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	274,646,700.00	423,432,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	274,646,700.00	423,432,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	300,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	27,819,500.00	31,975,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	27,819,500.00	31,975,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	306,725,786.27	459,082,146.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	306,725,786.27	459,082,146.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	306,723,132.75	457,649,953.44
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	189,489,294.63	311,444,868.15
210101	Цалин	141,767,833.63	209,578,115.59
210102	Нэмэгдэл цалин	44,145,402.60	96,622,952.56
210104	Урамшуулал	3,576,058.40	5,243,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,694,614.80	39,160,962.49
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	23,184,943.88	26,997,857.51
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	(2,002,938.92)	2,984,717.86
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,617,566.16	1,475,858.90
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	345,474.47	1,473,630.90
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	3,549,569.21	6,228,897.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,696,846.48	29,676,006.93
210301	Гэрэл цахилгааны зардал	5,706,926.48	6,653,422.93
210302	Түлш, халаалтын зардал	19,939,920.00	22,671,584.00
210303	Цэвэр, бохир усны зардал	50,000.00	351,000.00
2105	Нормативт зардал	30,010,463.00	37,944,647.00
210502	Хоол	30,010,463.00	37,944,647.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,319,800.00	1,658,700.00
210604	Урсгал засвар	3,319,800.00	1,658,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	525,000.00	451,390.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	525,000.00	451,390.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,987,113.84	37,313,378.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,834,600.00	10,886,178.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	2,802,900.00	6,764,960.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,349,613.84	19,662,240.87

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,653.52	1,432,193.07
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,653.52	1,432,193.07
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,653.52	1,432,193.07
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	31,520,397.73	25,811,753.49
5	НИЙТ ҮР ДҮН (VI=III+VI)	31,520,397.73	25,811,753.49

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

ДАНС	ITEM_NAME	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	302,466,200.00	455,708,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	302,466,200.00	455,708,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	274,646,700.00	423,432,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	274,646,700.00	423,432,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	300,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	27,819,500.00	31,975,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	27,819,500.00	31,975,700.00
xxx	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	278,351,772.01	433,502,338.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	278,351,772.01	433,502,338.64
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	278,349,118.49	432,070,145.57
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	182,642,907.54	310,759,050.33
210101	Үндсэн цалин	119,829,299.71	203,837,206.58
210102	Нэмэгдэл	58,536,339.93	101,964,982.41
210104	Үр дүнгийн урамшуулал	4,277,267.90	4,956,861.34
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	29,493,514.47	39,846,780.31
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	20,409,814.47	28,050,600.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,270,800.00	3,057,280.31
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,816,800.00	1,456,500.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	454,000.00	1,456,500.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	4,542,100.00	5,825,900.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	25,816,846.48	29,676,006.93
210301	Гэрэл цахилгааны зардал	5,706,926.48	6,653,422.93
210302	Түлш, халаалтын зардал	19,939,920.00	22,671,584.00
210303	Цэвэр, бохир усны зардал	170,000.00	351,000.00
2105	Нормативт зардал	27,337,250.00	36,178,090.00
210502	Хоол, хүнс	27,337,250.00	36,178,090.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	867,500.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	867,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	521,700.00	1,300,190.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	521,700.00	1,300,190.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,536,900.00	13,442,528.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,971,700.00	9,708,328.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	1,565,200.00	3,734,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,653.52	1,432,193.07
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,653.52	1,432,193.07
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,653.52	1,432,193.07
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	24,114,427.99	22,205,961.36
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	24,114,427.99	22,205,961.36
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,579,481.02	38,693,909.01
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	38,693,909.01	60,899,870.37

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	-	-	-	-
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	39,358,810.00	151,091,033.22	226,070,141.02	416,519,984.24
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	39,358,810.00	151,091,033.22	226,070,141.02	416,519,984.24
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	39,358,810.00	151,091,033.22	226,070,141.02	416,519,984.24
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	25,811,753.49	25,811,753.49
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	39,358,810.00	151,091,033.22	251,881,894.51	442,331,737.73

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 сарын 31

/төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	төлөвлөгөө	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	38,693,909.01	(38,693,909.01)	-
	ХӨТӨЛБӨР 71801	-	-	-	-
	АРГА ХЭМЖЭЭ 81807	-	-	-	-
2	1. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	36,222,400.00	36,178,090.00	44,310.00	99.88

21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	36,222,400.00	36,178,090.00	44,310.00	99.88
210	Бараа, үйлчилгээний зардал	36,222,400.00	36,178,090.00	44,310.00	99.88
2105	Нормативт зардал	36,222,400.00	36,178,090.00	44,310.00	99.88
210502	Хоол, хүнс	36,222,400.00	36,178,090.00	44,310.00	99.88
	ХӨТӨЛБӨР 71801	-	-	-	-
	АРГА ХЭМЖЭЭ 81833	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	2,885,789.49	(2,885,789.49)	-
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	2,885,789.49	(2,885,789.49)	-
210	Бараа, үйлчилгээний зардал	-	2,885,789.49	(2,885,789.49)	-
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	2,671,989.49	(2,671,989.49)	-
210101	Үндсэн цалин	-	2,671,989.49	(2,671,989.49)	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	213,800.00	(213,800.00)	-
210202	Тэтгэмжийн даатгал	-	53,500.00	(53,500.00)	-
210203	ҮОМШӨ ний даатгал	-	26,700.00	(26,700.00)	-
210204	Ажилгүйдлийн даатгал	-	26,700.00	(26,700.00)	-
210205	Эрүүл мэндийн даатгал	-	106,900.00	(106,900.00)	-
	ХӨТӨЛБӨР 71801	-	-	-	-
	АРГА ХЭМЖЭЭ 81834	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	372,392,600.00	348,830,949.76	23,561,650.24	93.67
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	372,392,600.00	348,830,949.76	23,561,650.24	93.67
210	Бараа, үйлчилгээний зардал	372,392,600.00	348,830,949.76	23,561,650.24	93.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	322,781,400.00	304,348,879.45	18,432,520.55	94.29
210101	Үндсэн цалин	218,874,000.00	198,479,522.04	20,394,477.96	90.68
210102	Нэмэгдэл	101,115,000.00	101,964,982.41	(849,982.41)	100.84
210104	Урамшуулал	2,792,400.00	3,904,375.00	(1,111,975.00)	139.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,347,600.00	39,447,680.31	899,919.69	97.77
210201	Тэтгэврийн даатгал	27,436,400.00	27,865,300.00	(428,900.00)	101.56
210202	Тэтгэмжийн даатгал	3,227,800.00	3,003,780.31	224,019.69	93.06
210203	ҮОМШӨ ний даатгал	1,613,900.00	1,429,800.00	184,100.00	88.59
210204	Ажилгүйдлийн даатгал	1,613,900.00	1,429,800.00	184,100.00	88.59
210205	Эрүүл мэндийн даатгал	6,455,600.00	5,719,000.00	736,600.00	88.59
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,300,200.00	1,300,190.00	10.00	100.00
210806	Мэдээллийн технологийн зардал	1,300,200.00	1,300,190.00	10.00	100.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	7,963,400.00	3,734,200.00	4,229,200.00	46.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,229,200.00	-	4,229,200.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,734,200.00	3,734,200.00	-	100.00
	ХӨТӨЛБӨР 71801	-	-	-	-
	АРГА ХЭМЖЭЭ 81835	-	-	-	-

2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,941,400.00	1,237,786.34	2,703,613.66	31.40
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	3,941,400.00	1,237,786.34	2,703,613.66	31.40
210	Бараа, үйлчилгээний зардал	3,941,400.00	1,237,786.34	2,703,613.66	31.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,503,500.00	1,052,486.34	2,451,013.66	30.04
210104	Урамшуулал	3,503,500.00	1,052,486.34	2,451,013.66	30.04
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	437,900.00	185,300.00	252,600.00	42.32
210201	Тэтгэврийн даатгал	297,800.00	185,300.00	112,500.00	62.22
210202	Тэтгэмжийн даатгал	35,000.00	-	35,000.00	-
210203	ҮОМШӨ ний даатгал	17,500.00	-	17,500.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	17,500.00	-	17,500.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	70,100.00	-	70,100.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	423,732,600.00	(423,732,600.00)	-
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	423,732,600.00	(423,732,600.00)	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	-	423,432,600.00	(423,432,600.00)	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	300,000.00	(300,000.00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	38,693,909.01	(38,693,909.01)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	60,899,870.37	(60,899,870.37)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	12.00	12.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	3.00	3.00	-	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 сарын 31

/төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	ХӨТӨЛБӨР 71801	-	-	-	-
	АРГА ХЭМЖЭЭ 80109	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	30,543,506.93	(30,543,506.93)	-
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	30,543,506.93	(30,543,506.93)	-
210	Бараа, үйлчилгээний зардал	-	30,543,506.93	(30,543,506.93)	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	29,676,006.93	(29,676,006.93)	-
210301	Гэрэл цахилгаан	-	6,653,422.93	(6,653,422.93)	-
210302	Түлш, халаалт	-	22,671,584.00	(22,671,584.00)	-
210303	Цэвэр, бохир ус	-	351,000.00	(351,000.00)	-
2106	Эд хогшил худалдан авах	-	867,500.00	(867,500.00)	-
210604	Урсгал засвар	-	867,500.00	(867,500.00)	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	31,975,700.00	(31,975,700.00)	-
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	31,975,700.00	(31,975,700.00)	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	-	31,975,700.00	(31,975,700.00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	(0.00)	0.00	-

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
---	---	---	------	--------	---

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Завхан аймгийн Нөмрөг сумын хүүхдийн цэцэрлэгийн чиглэл:

Цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын зорилго, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, хүүхдийг асрах, хамгаалах, тэдний хөгжил, төлөвшлийг дэмжсэн цогц үйл ажиллагаа эрхэлнэ.

Завхан аймгийн Нөмрөг сумын хүүхдийн цэцэрлэгийн зорилго:

Завхан аймгийн Нөмрөг сумын хүүхдийн цэцэрлэг нь бага насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийг дэмжиж, сургуульд бэлтгэх, суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж, ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэх зорилготой үйл ажиллагаагаа явуулж байгаа Боловсрол Шинжлэх Ухааны яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 60 арга хэмжээ төлөвлөснөөс 95 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Завхан аймгийн Нөмрөг сумын хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
2. Боловсролын ерөнхий хууль
3. Төрийн хэмнэлтийн тухай хууль
4. Төрийн албаны тухай хууль
5. Төсвийн тухай хууль
6. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
7. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
8. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
9. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
10. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
11. Хөдөлмөрийн тухай хууль
12. Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй бөгөөд "төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэх тухай", "орон нутагт ажилласны нэмэгдлийг тооцож олгох тухай", "цэцэрлэгийн хүүхдийн хоолны нэг өдрийн зардлын хэмжээг нэмэгдүүлэх" зэрэг Засгийн газрын тогоолуудад өөрчлөлт орсон байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Тус цэцэрлэг нь дотоод хяналтын нэгжгүй бөгөөд Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын дарга, санхүүгийн ажилтан төрийн сангийн мэргэжилтэн нар хяналт тавин ажиллаж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймгийн Нөмрөг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Завхан аймгийн Нөмрөг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 25,811.7 мянган төгрөгөөр буюу 6.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	38,693.9	60,899.9	22,206.0
Бараа материал	49,988.6	44,071.1	-5,917.5
Үндсэн хөрөнгө	327,837.5	337,360.8	9,523.3
Нийт хөрөнгө	416,520.0	442,331.7	25,811.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	416,520.0	442,331.7	25,811.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	416,520.0	442,331.7	25,811.7

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант онд:

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл өмнөх оноос 22,206.0 мянган төгрөгөөр өсч, бараа материал 5,917.5 мянган төгрөгөөр буурч, үндсэн хөрөнгө 9,523.3 мянган төгрөгөөр өсчээ.

Тус цэцэрлэг нь оны эхэнд 49,988.6 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант онд төсвийн хөрөнгөөр 50,286.1 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч 56,203.6 мянган төгрөгийн зарцуулалт хийснээр 44,071.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна.

Үндсэн хөрөнгийн хувьд 29,185.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг хандив тусламжаар орлогот авч бүртгэлд тусгажээ. Тайлант онд 19,662.2 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон байна.

Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Засгийн газрын 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар батлагдсан “төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэх тухай”, “орон нутагт ажилласны нэмэгдлийг тооцож олгох тухай” 82, 128 дугаар тогтоолуудын дагуу ажилчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл нэмэгдэж, төсвийг тодотгосноор тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсвөөс төсвөөс мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс мянган төгрөгөөр, нийт мянган төгрөг, зардлыг мянган төгрөг байхаар тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн, батлуулж ажилласан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын болон орон нутгийн төсвөөс мянган төгрөгийг олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 455,708.3 мянган төгрөг буюу 99.3 хувьтай байна. Энэ нь тайлант оны төсвийг хүүхдийн хоол, тогтмол зардал 2-оос бусад зардлыг 100 хувь зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган

төгрөгөөр/

Хөтөлбөр а хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс санхүүжих					
71801	Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөр	458,624.7	455,708.3	2,916.4	99.3
80233	Хүүхэд хамгааллын зардал	583.4	583.4	0	100
81605	Эрүүл мэндийг дэмжих зардал	950.0	950.0	0	100
81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал	37,242.5	36,178.1	1,064.4	97.1
81816	Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	1,841.0	1,841.0	0	100
81833		8,019.1	8,019.1	0	100
81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал	374,048.8	374,048.8	0	100
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	3,941.4	3,941.4	0	100
Дүн		426,626.2	425,164.8	11,029.9	97.1
80109	Тогтмол зардал	31,975.7	30,543.5	1,432.2	95.5
Нийт дүн		458,624.7	455,708.3	2,916.4	99.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 31,975.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, байр ашиглалттай холбоотой зардалд 29,676.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 867.5 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 1,432.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
	Хөдрөг харз ХХК болон 7 иргэн, нийт 8 гэрээг /шууд аргаар/	Хоол хүнс	36,222.4	36,178.1
	Эл Би Си ХХК шууд гэрээ	дулаан	22,671.6	22,671.6
	ДҮН		58,894.0	58,849.7

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Завхан аймгийн Нөмрөг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторовын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан соёмбо аудит ХХК-ний аудитор Р.Мядагмаа хийж, анхан шатны хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн Нөмрөг сумын хүүхдийн цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 1.5 хувиар тооцож, 4,175.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75,0 хувь буюу 3,131.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, гүйцэтгэлийн үе шатанд материаллаг түвшинг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завхан аймгийн Нөмрөг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар эд хөрөнгийн тооллогыг үнэн зөв, бодитой хийж, тооллогын баримтыг бүрэн бүрдүүлэх талаар 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан бөгөөд хариу тайлбарыг эрхлэгчийн 2024 оны 6 дугаар сарын 04-ны өдрийн 3/016 тоотоор аймгийн Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна. Гэвч 2024 оны жилийн эцсийн байдлаар эд хариуцагч солигдох үед тооллого хийсэн боловч тооцоог бодож үр дүнг тооцоогүй, тооллогын бүртгэлийг бичиж гарын үсгээр баталгаажуулаагүй байв.

Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Бүлгүүдийн ирцийн бүртгэл, хоолны цэс, хоолны тайланг сар бүрийн баримтанд хавсаргаж байх, 1 хүүхдэд өгөх хоолны нормативыг барьж ажиллах
2. Гэрэл цахилгаан, дулааны нэхэмжлэлийг авч, төлбөрийг хийхдээ нэхэмжлэлд бичигдсэн квт, талбайн хэмжээг хянаж байх

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 441.3 мянган төгрөгийн алдаа илэрч, 441.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 3 зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт: Бүлгийн багшийг арга зүйч албан тушаалд дэвшүүлэн ажиллуулж үр дүнгийн урамшуулал олгосон нь Засгийн газрын 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолын 4.4 "багш нь урамшуулал авч байх хугацаандаа өөр ажилд шилжин ажилласан тохиолдолд урамшууллыг зогсооно", БШУС-ын 2022 оны А/430 дугаар тушаалын 4.9 "багш нэмэгдэл авч байх хугацаандаа багш бус ажилд шилжин ажилласан тохиолдолд төрөөс санхүүжих урамшууллыг зогсооно" заалтуудыг зөрчсөн байна.

5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй

5.3 Зөвлөмж:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илэрүүлэлт: 2024 онд шинээр авч гэрчилгээжүүлсэн 2955 м.кв газрыг бүртгэлд тусгаагүй, бүртгэлд байгаа 6031 м.кв газрын гэрчилгээг шинэчлээгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71.1.1-д "Үндсэн хөрөнгөд гарсан хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодохын дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байх, техник, технологийн баримт бичгийг гүйцэд бүрдүүлсэн байх"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4.-д "Үнэн зөв байх" зэрэг заалтуудтай нийцэхгүй байгаа нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Газрын хэмжээ, үнэлгээг дахин нягталж, бүртгэлд бүрэн тусгах

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илэрүүлэлт: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 0 үлдэгдэлтэй 67 нэр төрлийн 41.043.071 төгрөгийн хөрөнгө дансанд бүртгэлтэй байгаа нь ТБОНӨ-ийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 "төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдсэн үндсэн хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно", 31.3.2 "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шитгэлээрээ анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг ТӨБЗ-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 0 үлдэгдэлтэй хөрөнгүүдийг акталж устгах, дахин үнэлүүлэх арга хэмжээ авч ажиллах.

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илэрүүлэлт: Эд хариуцагч солигдох үед тооллого хийж, тооцоо бодоогүй, жилийн эцсийн тооллого хийсэн боловч тооцоо бодож үр дүнг тооцоогүй, шатахууны картын үлдэгдлийг баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1 "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 12.2.2 "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед", 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Тооллогыг хуульд заасан хугацаанд заавал хийж, тооцоог бодож, үр дүнг тооцож хэвших

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шавардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцүүлэх албан шавардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бүлгийн багшийг арга зүйч албан тушаалд дэвшүүлэн ажиллуулж үр дүнгийн урамшуулал олгосон	1	441.3	1	441.3								
Эд хариуцагч солигдох үед тооллого хийж, тооцоо бодоогүй, жилийн эцсийн тооллого хийсэн боловч тооцоо бодож үр дүнг тооцоогүй, шатахууны картын үлдэгдлийг багалгаажуулаагүй байна.	1	0					1	0				
2024 онд шинээр авч гэрчилгээжүүлсэн 2955 м.кв газрыг бүртгэлд аваагүй, бүртгэлд байгаа 6031 м.кв газрын гэрчилгээг шинэчлээгүй байна.	1	0					1	0				
Элэгдээрээ анхны өртгөө нөхсөн 67 нэр төрлийн 41,043,071 төгрөгийн хөрөнгө дансанд бүртгэлтэй байна.	1	0					1	0				
Дүн	4	441.3	1	441.3			3	0				

АУДИТЫН ТАЙЛАНГ:
 ХЯНАСАН: Ц.ОЮУНСУВД
 АХЛАХ АУДИТОР
 АУДИТЫН МЕНЕЖЕР: Х.БОЛДБААТАР
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Д.БАТ-УНДРАА

БОЛОВСРУУЛСАН:
 "ХААН СОЁМБО АУДИТ" ХХК-НИЙ АУДИТОР
 Огноо: 2025-02-24
 Огноо: 2025-02-24
 Р.МЯДАГМАА